

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/57/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99900662 Цахим хаяг:
tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: С.Гансүх

Утас: 95908400 Цахим хаяг:
gansukhsa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/218
танай _____-ны № _____-т

ИХ-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАЯРМАА ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Их-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Их-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Их-Уул сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолын дагуу орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого зохион байгуулах хүрээнд байгууллагын үндсэн хөрөнгийг тоолж баталгаажуулсан байна.

Аудитын гол асуудал

Их-Уул сум нь 2021 онд сумын 90 жилийн ойг тэмдэглэх байсныг цар тахлын улмаас хойшлогдож тайлант онд тэмдэглэн өнгөрүүлсэн. Үүнтэй холбоотойгоор иргэн, аж ахуйн нэгжээс 2021 онд 65,690.0 мянган төгрөгийн хандив цугласныг тайлант онд ойн арга хэмжээнд зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Их-Уул сумын Засаг даргын Тамгын газар нь 3 хөтөлбөр 10 арга хэмжээг хэрэгжүүлэн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 87.5 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт


Handwritten signatures and dates at the bottom right of the page.

олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	133,503,069.20	66,685,719.20
33	АВЛАГА	65,690,000.00	00.00
335	Бусад авлага	65,690,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	65,690,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	67,813,069.20	66,685,719.20
354	Хангамжийн материал	67,813,069.20	66,685,719.20
35410	Бичиг хэргийн материал	627,800.00	431,500.00
35420	Аж ахуйн материал	42,477,469.20	41,546,419.20
35470	Бусад хангамжийн материал	24,707,800.00	24,707,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,999,140,039.70	3,126,034,417.05
39	Үндсэн хөрөнгө	2,999,140,039.70	3,126,034,417.05
392	Биет хөрөнгө	2,945,885,758.76	3,052,532,710.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,148,791,884.20	3,163,567,884.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	92,474,800.00	298,162,184.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	128,404,220.00	180,816,252.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,912,976.00	36,562,976.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,000,000.00	5,000,000.00
393	Биет бус хөрөнгө	53,254,280.94	73,501,706.28
39301	Програм хангамж	3,195,000.00	3,195,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	50,669,280.94	71,555,706.16
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,132,643,108.90	3,192,720,136.25
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,132,643,108.90	3,192,720,136.25
51	Засгийн газрын хувь оролцоо	3,132,643,108.90	3,192,720,136.25
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	394,199,768.11	394,199,768.11
51101	Өмч: - төрийн	394,199,768.11	394,199,768.11
512	Хуримтлагдсан үр дүн	2,554,101,551.01	2,614,178,578.36
51210	Өмнөх үеийн үр дүн	2,554,101,551.01	2,554,101,551.01
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	60,077,027.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	184,341,789.78	184,341,789.78
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,132,643,108.90	3,192,720,136.25

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,079,293,463.20	846,715,441.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,475,028,595.20	254,212,241.22
120	Нийтлэг татварын бус орлого	1,475,028,595.20	254,212,241.22
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,960,500.00	4,613,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,960,500.00	4,613,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	604,264,868.00	592,503,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	70,751,968.00	7,403,300.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	65,690,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,928,968.00	6,160,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,133,000.00	1,242,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	533,512,900.00	585,099,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	533,512,900.00	585,099,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	684,433,016.94	786,638,413.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	684,433,016.94	786,638,413.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	579,902,296.94	688,465,953.87

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	256,171,000.00	265,419,033.00
210101	Үндсэн цалин	256,171,000.00	204,446,645.00
210102	Нэмэгдэл	00.00	31,388,930.00
210104	Урамшуулал	00.00	29,583,458.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,508,080.00	33,666,235.00
210201	Тэтгэврийн даатгал	23,267,678.00	22,968,072.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,561,710.00	2,738,356.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,049,368.00	2,123,405.00
210204	Ажилгүйдлийн даатгал	505,903.00	528,012.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,123,421.00	5,308,390.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,666,600.00	81,365,700.00
210301	Гэрэл, цахилгаан	3,050,000.00	3,877,735.00
210302	Түлш, халаалт	63,416,600.00	76,860,224.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	627,741.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,862,623.00	40,108,150.00
210401	Бичиг хэрэг	3,421,300.00	3,722,400.00
210402	Тээвэр, шатахуун	11,401,402.00	16,932,210.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,534,650.00	3,530,190.00
210404	Ном, хэвлэл	180,000.00	87,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,944,000.00	9,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,539,661.00	6,836,050.00
210408	Бараа материал акталсны зардал	2,841,610.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,225,100.00	6,104,800.00
210604	Урсгал засвар	11,225,100.00	6,104,800.00
2107	Томилолт, зочны зардал	1,343,000.00	2,000,000.00
210702	Дотоод албан томилолт	1,343,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,209,916.00	56,271,222.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,529,066.00	55,176,544.00
210803	Даатгалын үйлчилгээ	64,350.00	172,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	97,200.00	75,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	15,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,500.00	600,000.00
210807	Газрын төлбөр	249,800.00	231,578.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	160,915,977.94	203,530,813.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,673,000.00	20,813,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	2,200,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	144,242,977.94	180,517,463.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	104,530,720.00	98,172,460.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,661,900.00	62,774,120.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	19,357,320.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,261,900.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400,000.00	43,416,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	54,868,820.00	35,398,340.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	54,868,820.00	35,398,340.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,394,860,446.26	60,077,027.35
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	12,865,106.14	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	8,661,106.14	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	4,204,000.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,381,995,340.12	60,077,027.35

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	613,582,368.00	662,806,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,960,500.00	4,613,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,960,500.00	4,613,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,960,500.00	4,613,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,960,500.00	4,613,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	611,621,868.00	658,193,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	78,108,968.00	73,093,300.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	65,690,000.00	65,690,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,928,968.00	6,160,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,490,000.00	1,242,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	533,512,900.00	585,099,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	533,512,900.00	585,099,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	608,583,368.00	602,573,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	608,583,368.00	602,573,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	438,362,648.00	504,401,140.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	255,813,000.00	265,419,033.00
210101	Үндсэн цалин	255,813,000.00	204,446,645.00
210102	Нэмэгдэл	00.00	31,388,930.00
210104	Урамшуулал	00.00	29,583,458.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,508,080.00	33,666,235.00
210201	Тэтгэврийн даатгал	23,588,500.00	22,968,072.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,468,500.00	2,738,356.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,985,380.00	2,123,405.00
210204	Ажилгүйдлийн даатгал	496,900.00	528,012.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,968,800.00	5,308,390.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,666,600.00	81,365,700.00
210301	Гэрэл, цахилгаан	3,050,000.00	3,877,735.00
210302	Түлш, халаалт	63,416,600.00	76,860,224.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	627,741.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,866,952.00	35,060,800.00
210401	Бичиг хэрэг	3,569,700.00	3,511,100.00
210402	Тээвэр, шатахуун	11,401,402.00	16,932,210.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,534,650.00	3,530,190.00
210404	Ном, хэвлэл	180,000.00	87,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,944,000.00	9,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,237,200.00	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,225,100.00	6,104,800.00
210604	Урсгал засвар	11,225,100.00	6,104,800.00
2107	Томилолт, зочны зардал	1,343,000.00	2,000,000.00
210702	Дотоод албан томилолт	1,343,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,266,916.00	56,271,222.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,586,066.00	55,176,544.00
210803	Даатгалын үйлчилгээ	64,350.00	172,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	97,200.00	75,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	15,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,500.00	600,000.00
210807	Газрын төлбөр	249,800.00	231,578.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,673,000.00	24,513,350.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,673,000.00	22,313,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	2,200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	170,220,720.00	98,172,460.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,661,900.00	62,774,120.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	19,357,320.00

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,261,900.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400,000.00	43,416,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	120,558,820.00	35,398,340.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	120,558,820.00	35,398,340.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,999,000.00	60,233,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,999,000.00	60,233,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,999,000.00	60,233,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,999,000.00	60,233,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,999,000.00	60,233,000.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	394,199,768.11	185,550,399.78	1,170,897,600.89	1,750,647,768.78
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,208,610.00	1,208,610.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	394,199,768.11	185,550,399.78	1,172,106,210.89	1,751,856,378.78
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,381,995,340.12	1,381,995,340.12
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	394,199,768.11	184,341,789.78	2,554,101,551.01	3,132,643,108.90
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	394,199,768.11	184,341,789.78	2,554,101,551.01	3,132,643,108.90
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	394,199,768.11	184,341,789.78	2,554,101,551.01	3,132,643,108.90
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	60,077,027.35	60,077,027.35
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	394,199,768.11	184,341,789.78	2,614,178,578.36	3,192,720,136.25

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	590,769,900.00	554,384,960.00	-36,384,940.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	530,769,900.00	510,727,960.00	-20,041,940.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	501,450,600.00	484,293,840.00	-17,156,760.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	270,181,100.00	265,419,033.00	-4,762,067.00

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	197,166,800.00	204,446,645.00	7,279,845.00
210102	Нэмэгдэл	44,822,200.00	31,388,930.00	-13,433,270.00
210104	Урамшуулал	28,192,100.00	29,583,458.00	1,391,358.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,772,800.00	33,666,235.00	-106,565.00
210201	Тэтгэврийн даатгал	21,749,300.00	22,968,072.00	1,218,772.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,347,200.00	2,738,356.00	-1,608,844.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,047,000.00	2,123,405.00	76,405.00
210204	Ажилгүйдлийн даатгал	511,800.00	528,012.00	16,212.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,117,500.00	5,308,390.00	190,890.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,550,200.00	81,365,700.00	-184,500.00
210301	Гэрэл, цахилгаан	4,000,000.00	3,877,735.00	-122,265.00
210302	Түлш, халаалт	75,850,200.00	76,860,224.00	1,010,024.00
210303	Цэвэр, бохир ус	1,700,000.00	627,741.00	-1,072,259.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,180,000.00	33,180,000.00	0.00
210401	Бичиг хэрэг	3,500,000.00	3,511,100.00	11,100.00
210402	Тээвэр, шатахуун	14,900,000.00	15,051,410.00	151,410.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,600,000.00	3,530,190.00	-69,810.00
210404	Ном, хэвлэл	180,000.00	87,300.00	-92,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,000,000.00	9,000,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	2,000,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,604,800.00	14,604,800.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,500,000.00	8,500,000.00	0.00
210604	Урсгал засвар	6,104,800.00	00.00	-6,104,800.00
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	2,000,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	2,000,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,961,700.00	31,044,722.00	-6,916,978.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,165,100.00	29,950,044.00	-6,215,056.00
210803	Даатгалын үйлчилгээ	227,700.00	172,600.00	-55,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	251,500.00	75,500.00	-176,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	15,000.00	-106,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000.00	600,000.00	0.00
210807	Газрын төлбөр	596,400.00	231,578.00	-364,822.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,200,000.00	23,013,350.00	-5,186,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,000,000.00	20,813,350.00	-5,186,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,200,000.00	2,200,000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29319300.00	26434120.00	-2,885,180.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,319,300.00	26,434,120.00	-2,885,180.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	19,359,300.00	19,357,320.00	-1,980.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	160,000.00	00.00	-160,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,800,000.00	7,076,800.00	-2,723,200.00

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	60,000,000.00	43,657,000.00	-16,343,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	60,000,000.00	43,657,000.00	-16,343,000.00
223001	Бусад хөрөнгө	60,000,000.00	43,657,000.00	-16,343,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	590,769,900.00	554,384,960.00	-36,384,940.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	585,099,900.00	549,771,560.00	-35,328,340.00
132001	Орон нутгийн төсвөөс	585,099,900.00	549,771,560.00	-35,328,340.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,670,000.00	4,613,400.00	-1,056,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,670,000.00	4,613,400.00	-1,056,600.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	24.00	0.00
620001	Удирдах ажилтан	08.00	08.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	08.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	0.00
620004	Гэрээт ажилтан	03.00	03.00	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төгрөгөөр/
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН			73,023,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ			73,023,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ			36,683,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал			1,880,800.00
210401	Бичиг хэрэг			00.00
210402	Тээвэр, шатахуун			1,880,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж			33,302,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж			33,302,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал			1500000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал			1,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ			36,340,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг			36,340,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал			36,340,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР			73,023,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого			73,023,300.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж			65,690,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө			6,160,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого			1,172,500.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Их-Уул сумын ЗДТГ нь тухайн орон нутагт хууль журамд заасан чиг үүрийг орон нутагт хэрэгжүүлэх, ард иргэдийг мэдээллээр хангах үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна. 2022 онд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлэх” гэсэн зорилго тавьж, түүнийгээ биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, аюулгүй байдал хууль ёсны эрх ашгийг хамгаалах
2. Үйл ажиллагаандаа мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж шуурхай байдлыг хангах
3. Байгууллагын техник хэрэгслийн ашиглалтыг сайжруулах, хариуцагчтай болгож, бүтээн байгуулалтын ажлуудад бүрэн ашиглаж хөрөнгө оруулалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулах
4. Иргэдэд үзүүлэх үйлчилгээг чанарт шилжүүлэх шат дамжлагыг бууруулах
5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нэрлэсэн жилийн хүрээнд ажлын байр бий болгох

ЗДТГ-ын дарга нь нь сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 87.5 хувьтай биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль болон бусад хууль тогтоомж журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой байгууллагын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг баримталж ажилласан байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу Засаг даргын захирамжаар 2021 оны 09 сарын 21 өдрийн А/17 тоот тушаалаар дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 6 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын нэг, хоёрдугаар үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Их-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж,

Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсрол, соёлын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Их-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 60,007.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б			
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	65,690.0	0	-65,690.0
Бараа материал	67,813.1	66,885.7	-1,127.4
Үндсэн хөрөнгө	2,999,140.0	3,126,034.4	126,894.4
Нийт хөрөнгө	3,132,643.1	3,192,720.1	60,007.0
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,132,643.1	3,192,720.1	60,007.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,132,643.1	3,192,720.1	60,007.0

Дээрх хүснэгтээс харахад авлага, бараа материал данс өмнөх оноос буурч, үндсэн хөрөнгө данс өссөн үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд болон өмнөх онд мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлгүй байна.
2. 2021 онд сумын түүхт 90 жилийн ой болох боловч цар тахлын улмаас хойшлогдож тайлант онд тэмдэглэн өнгөрүүлсэн. Үүнтэй холбоотойгоор 2021 оны хандивыг нэмэлт дансанд байршуулж авлага үүсгэн татан төвлөрүүлсэн. Уг хандивыг тайлант онд ойн арга хэмжээнд зарцуулсан.
3. Бараа материал данс өмнөх оноос 1,127.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд бичиг хэргийн болон аж ахуйн материалын өмнөх оны үлдэгдлээс зарцуулсантай холбоотой.
4. Үндсэн хөрөнгө данс 126,894.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд улсын төсвийн болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, хандив тусламжаар 247,174.8 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 60,233.0 мянган төгрөгөөр худалдан авснаар нэмэгдэж, элэгдлийн зардал 180,517.5 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

2022 оны төсвийг Аймгийн ИТХ-ын тогтоолоор орон нутгийн төсвөөр санхүүжүүлэх дүнг 506,7646.0 мянган төгрөгөөр баталсан байна. Орон нутгийн төсвөөс авах дүн нэмэгдсэн нь

цалингийн үр дүнгийн урамшуулал болон байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой.

Засаг даргын тамгын газрын төсөв нь Сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 06 дугаар тогтоолоор 534,091.1 мянган төгрөгөөр батлагдаж 2022 оны 06 дүгээр сарын 29-ний өдрийн 02 дугаар тогтоолоор тодотгол хийгдэж 582,186.0 мянган төгрөг болон батлагдсан. Аймгийн засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/429 тушаалаар төсөвт зохицуулалт хийгдэж 590,769.9 мянган төгрөг болон өөрчлөлт хийгдсэн

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 590,769.9 мянган төгрөг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр төсөвлөгдсөн.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 585,099.9 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,056.6 мянган төгрөг дутуу бүрүүлсэн. Зарцуулаагүй үлдэгдэл 35,328,3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 545,757.0 мянган төгрөг буюу 93,8 хувьтай байгаа нь төрийн хэмнэлтийн хуулийн дагуу хөрөнгийн зардал шагнал урамшлын зардлыг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	510,944.8	494,826.9	16,117.9	96,8
2	Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	60,000.0	43,657.0	16,343.0	72.8
3	Байгаль орчин хамгаалан нөхөн сэргээх	19,825.1	15,901.1	3,934.0	80.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансанд Хүүхэд залуучуудын хөгжлийн газраас “Хүүхэд хамгааллын хамтарсан багийн урамшуулал 500.0 мянган төгрөг, БТСГ-аас нийтийн биеийн тамирын үйл ажиллагаанд 1,500.0 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогын зардал 3,710.8 мянган төгрөг, Аймгийн ИТХ-аас хамтарсан багийн дэмжлэг 300.0 мянган төгрөг, ХХҮГ-аас ХАБ-ын ажилтны урамшуулал 150.0 мянган төгрөг, ТӨБЗГ-аас цахим тендерийн хураамж 157.5 мянган төгрөг, ахмадын байрны түрээсийн орлого 1,015.0 мянган төгрөг, өмнөх онд иргэдээс хандивласан 65,690.0 мянган төгрөг нийт 73,023.3 мянган төгрөгийн орлого орсон байна.

Нэмэлт санхүүжилтийн орлогоос 72,955.3 мянган төгрөгийг зарцуулж 70.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Их-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Гансүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Их-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 3/37 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 13,688.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10,950.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь тайлант онд нийт 36,384.9 мянган төгрөгийг цалингийн зардал, хөрөнгийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, шагнал урамшууллын зардлаас хэмнэж ажилласан байна.

Тус байгууллагад Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 29 асуудлаар горим сорилыг хэрэгжүүлсэн. Горим сорилыг хэрэгжүүлэх явцад төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь 1 мэдээллийг хугацаа хоцрон оруулж, бусад мэдээллийг хугацаанд нь мэдээлж ажилласан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Их-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар туслах үйл ажиллагааны орлого, зарцуулалттай холбоотой асуудал байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 599.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн. Аудитаар 599.4 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага хариуцлага тооцох санал хүргүүлээгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Их-Уул сумын Засаг даргын Тамгын газар нь Тайлант онд спорт заалнаас 4,613,400 төгрөгийн орлого олсон олж, арга зүйч, үйлчлэгчээр 2 хүнийг гэрээгээр ажиллуулж 5,212,826 төгрөгийн цалин, НДШ-ийн зардал гарган зөрүү 599,426 төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардлаас зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 44.3 “Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно” заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Туслах үйл ажиллагаатай холбоотой гарах зардлыг тухайн орлогоос хэтрүүлэн зарцуулахгүй байх Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж хөрөнгө зарцуулсан	1	599.4					1	599.4				
Дүн	1	599.4					1	599.4				

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
 АУДИТЫН МЕНЕЖЕР
 БАТАЛГААЖУУЛСАН:
 АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б. ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

С. ГАНСҮХ ОГНОО:

2/16
 13/11